

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 1 дүгээр сарын 29

№ 04

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2018 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 08 цаг 30 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд удирдаж, хуралд нийт 22 гишүүд оролцож, Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат хуралд оролцсонгүй. Хуралдааны ирц 95.83 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, агентлагийн дарга нар 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд:

| № | Өгөгдсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн |
|----|--|--|
| 1. | Тээврийн хэрэгслийг зөөн шилжүүлэх, түр саатуулах байрны үнийг тогтоох журамд анхаарах, ХАСХОМ-гийг хугацаанд нь мэдүүлэхийг төрийн албан хаагчдад сануулах, Дархан сумын дахин төлөвлөлтийн 6 айлын гэрээг яаралтай хийх шаардлагатай байна. | Хууль, эрх зүйн хэлтэс, |
| 2. | Дархан сум багийн Засаг даргад үүрэг өгч дахин төлөвлөлтийн асуудлаар гэрээ байгуулж чадаагүй байгаа 6 айлын гэрээг байгуулах, гадаадад амьдарч байгаа хамтран өмчлөгч нарын асуудлыг яаралтай шийдвэрлэх, Ажлын хэсэгт Дархан сумаас нэг гишүүн оролцсон боловч нэг ч удаа ажлын хэсгийн хуралд суугаагүй. Энэ ажил оролцох шаардлагатай байна. | Дархан сумын Засаг даргын Тамгын газар |
| 3. | Цагдаагийн байгууллагын саатуулагдсан төрийн албан хаагч болон оюутан сурагч нарт анхаарах заавал арга хэмжээ авч хариуцлага тооцох шаардлагагүй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Байгууллага болон сургуулийн удирдлагуудад мэдэгдэх, албан бичиг өгөх | Хууль, эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс |
| 4. | Гал түймэр гарч байгаа тухай мэдээлэл өгч байна. Үүнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахад анхаарах | Онцгой байдлын газар |
| 5. | Мэргэжлийн хяналтын газрын шалгалтад эрчим хүчний байгууллагуудын аюулгүй байдал, стандартын шаардлага хангаагүй байгаа тухай мэдээллүүдийг хийсэн. Эрчим хүчний байгууллагын аюулгүй нөөцийн асуудлыг дурдаж байна. Захирагчийн албанд МХГ-аас илтгэх хуудсыг хүргүүлэх зөрчлийг арилгуулах тал дээр хамтран ажиллах | Захирагчийн алба Мэргэжлийн хяналтын газар |
| 6. | “Хуулиа дээдэлье” сарын аян маш удаан явагдаж байна. Байгууллагуудаас сарын аяныг зохион байгуулахтай холбогдуулан хийж байгаа ажлыг үр | Мэргэжлийн хяналтын газар, Бүх байгууллагууд |

| | | |
|-----|--|--|
| | дүнтэй, чанартай зохион байгуулах шаардлагатай байна. | |
| 7 | 4 сумын ЗДТГазар болон ОБГазар хамтран нөөцийн өвс борлуулалтад анхаарах 4 сум нөөцийн өвсөө борлуулахдаа өөр өөр үнээр зарж байгаа учраас иргэд аль хямд зарж байгаа газраас нөөцийн өвс авах сонирхол үүснэ. Зөвхөн өөрийн сумын иргэдэд нөөцийн өвсөө борлуулах тал дээр анхаарах, мөн нөөцийн өвсийг их хэмжээгээр авч байгаа аж ахуй нэгж байгууллагуудад хяналт тавих хямд үнээр аваад цааш нь малчдад үнийг нь өсгөж зарах асуудал гарахаас урьдчилан сэргийлэх | Сумдын ЗДТГ, Онцгой байдлын газар |
| 8. | Малын өвчлөл, вакцинжуулалт, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, албаны холбогдох мэргэжилтнүүдийг малчин айл өрхөөр явуулж санал сонсох, эргэж хяналт тавих, малын голомтоос мал шилжиж ирэхээс урьдчилан сэргийлэх | Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар |
| 9. | Малын өвчлөлтэй холбоотой Засгийн газрын тогтоол ирүүлснийг ХОХБТХэлтэст шилжүүлсэн байгаа уг тогтоолыг сумдад хүргүүлэх тогтоолын хэрэгжилтийг хангах ажиллахад анхаарах | Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| 10. | Цагаан сарын үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцдог Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Хэний аймаг гэх мэт аймгуудад сайтар мэдээлэл өгөх | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| 11. | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас тендерт оролцож байгаа байгууллагуудаас зураг төсвийг /Багийн төвийн байр, цэцэрлэгийн зураг төсөв гэх мэт/ яаралтай шахаж авч дуусгах, улсын магадлалд оруулах | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар |
| 12. | Үйлдвэрийн районд шинээр хогийн цэг үүсэж байгаа тухай иргэний мэдээлэл ирсний дагуу постын хяналтыг тавихдаа хотоос гарч байгаа авто машинуудын ачааг шалгаж, хяналт тавих шаардлагатай байна. Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Захирагчийн алба, Дархан сумын ЗДТГазар, Онцгой байдлын газар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, Захирагчийн алба хогийн цэг шинээр бий болохоос урьдчилан сэргийлэх | Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Захирагчийн алба, Дархан сумын ЗДТГазар, Онцгой байдлын газар |
| 13. | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс өвлийн хүлэмжийн асуудал анхаарлаа хандуулах хууль, дүрэм, гэрээг судалж хэрхэн шийдвэрлэх талаар анхаар ч ажиллах, холбогдох удирдлагуудыг дуудаж уулзах | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| 14. | Орон нутгийн өмчийн газар, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс тендерийн үйл ажиллагаанд анхаарах | Орон нутгийн өмчийн газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| 15. | Татварын орлогын бүрдүүлэлтэд анхаарах | Татварын хэлтэс |
| 16. | “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад анхаарах бэлтгэл ажлыг сайтар хангах | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| 17. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөмж өгөх шаардлагатай байна. Зөвхөн үнэлгээ хийж байна. Хөтөлбөр ямар учир шалтгаанаар хэрэгжилт 30%, 70% гарсан, ямар гарц байна. Төлөвлөлт болон цаашид | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |

| | | |
|-----|---|--|
| | хэрхэн засах талаар зөвлөн туслах үйлчилгээ өгөх шаардлагатай байна. | |
| 18. | Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй боловч хийсэн ажил нь байна. Зарим газрууд үүрэг даалгаврын хэрэгжилт өгөхгүй байна. 1 дүгээр сарын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилт танилцуулагдаж байсан. Үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2 дугаар сарын 01-нд дүнг танилцуулж арга хэмжээ авах | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс |

Хурал 10 цаг 00 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ

2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2018 оны 02 дугаар сарын 12

№ 04

Дархан-Уул аймаг

| № | Өгөгдсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн | Хэрэгжилт |
|----|--|--|---|
| 1. | Тээврийн хэрэгслийг зөөн шилжүүлэх, түр саатуулах байрны үнийг тогтоох журамд анхаарах, ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлэхийг төрийн албан хаагчдад сануулах, Дархан сумын дахин төлөвлөлтийн 6 айлын гэрээг яаралтай хийх шаардлагатай байна. | Хууль, эрх зүйн хэлтэс, | Хэлэлцүүлэгийн тэмдэглэлийг боловсруулан, иргэдээс гаргасан саналыг бүрэн тусгаж аймгийн ИТХ-д хүргүүллээ. Аймгийн ЗДТГ-т ХАСХОМ гаргаж өгөх 92 албан тушаалтнаас 25 албан хаагчийн ХАСХОМ хүлээн авч, зөвлөгөө өгч бүртгэж авлаа. Аймгийн хэмжээнд 182 ХАСХОМ-ээс 70 албан хаагч мэдүүллээ. |
| 2. | Дархан сум багийн Засаг даргад үүрэг өгч дахин төлөвлөлтийн асуудлаар гэрээ байгуулж чадаагүй байгаа 6 айлын гэрээг байгуулах, гадаадад амьдарч байгаа хамтран өмчлөгч нарын асуудлыг яаралтай шийдвэрлэх, Ажлын хэсэгт Дархан сумаас нэг гишүүн оролцсон боловч нэг ч удаа ажлын хэсгийн хуралд суугаагүй. Энэ ажил оролцох шаардлагатай байна. | Дархан сумын Засаг даргын Тамгын газар | 6 дугаар багийн Засаг дарга Р.Урангуад 61, 62, 63 дугаар бракад оршин суудаг 4 өрхийн гэрээг байгуулах талаар холбогдох иргэдэд мэдээлэл өгч яаралтай гэрээ байгуулахыг анхааруулаа. /ХЭЗХ/ |
| 3. | Цагдаагийн байгууллагын саатуулагдсан төрийн албан хаагч болон оюутан сурагч нарт анхаарах заавал арга хэмжээ авч хариуцлага тооцох шаардлагагүй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Байгууллага болон сургуулийн удирдлагуудад мэдэгдэх, албан бичиг өгөх | Хууль, эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс | Нэгдсэн эмнэлэг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шат дараалалтай 1 сарын хугацаанд зохион байгуулахаар байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх баг болон Цагдаагийн газартай хамтран ажиллаж байна. ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн Сургууль “Архигүй орчин-Гэрэлт ирээдүй” сэдэвт аяныг 2 сарын 2-оос 2 сарын-9-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна. |
| 4. | Гал түймэр гарч байгаа тухай мэдээлэл өгч байна. Үүнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахад анхаарах | Онцгой байдлын газар | үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй |
| 5. | Мэргэжлийн хяналтын газрын шалгалтад эрчим хүчний байгууллагуудын аюулгүй байдал, стандартын шаардлага | Захирагчийн алба Мэргэжлийн хяналтын | Эрчим хүчний үйлдвэр, ААНБ-уудын аюулгүй нөөцийн бүрдүүлэлтийн байдалд хийсэн урьдчилан сэргийлэх хяналтын |

| | | | |
|-----------|---|---|--|
| | <p>хангаагүй байгаа тухай мэдээллүүдийг хийсэн. Эрчим хүчний байгууллагын аюулгүй нөөцийн асуудлыг дурдаж байна. Захирагчийн албанд МХГ-аас илтгэх хуудсыг хүргүүлэх зөрчлийг арилгуулах тал дээр хамтран ажиллах</p> | <p>газар</p> | <p>ажлын танилцуулга болон ДДЦС ТӨХК, Эмт наран ОНӨҮГ, Дулаан шарын гол ТӨХК-иудад зөрчлийг арилгуулахаар өгсөн хугацаатай албан шаардлагын хуулбарыг аймгийн Засаг даргад 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/034 тоот албан бичгээр хүргүүлсэн. Аймгийн эрчим хүчний үйлдвэр, төвлөрсөн дулаан халаалтын зуух бүхий аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдал, аюулгүй нөөцийн бүрдүүлэлтэд хийсэн шалгалтын танилцуулга, аж ахуйн нэгж байгууллагуудад өгсөн албан шаардлагын дагуу “ДДЦС” ТӨХК, “Дулаан Шарын Гол” ТӨХК, “ЭМТ Наран” ОНӨҮГ-н удирдлагуудад цаг хугацаанд нь зөрчлийг барагдуулах талаар хяналт тавин ажиллаж байна</p> |
| <p>6.</p> | <p>“Хуулиа дээдэлье” сарын аян маш удаан явагдаж байна. Байгууллагуудаас сарын аяныг зохион байгуулахтай холбогдуулан хийж байгаа ажлыг үр дүнтэй, чанартай зохион байгуулах шаардлагатай байна.</p> | <p>Мэргэжлийн хяналтын газар, Бүх байгууллагууд</p> | <p>“Хуулиа мөрдье-21” сарын аян дуусч дүнгээ нэгтгэж байна. 16 заалттай төлөвлөгөө 100% биелсэн. Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдад архи, согтууруулах ундаа худалдах үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 302 худалдааны газар, 90 баар, кафе, зоогийн газар, 25 зочид буудал, СӨББ, ЕБС, их дээд сургуулийн 69 нийт 486 аж ахуйн нэгж байгууллагад 723 ширхэг “21 нас хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдах, үйлчлэхгүй талаар хууль сурталчилсан” зурагт хуудсыг нааж, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг сурталчилсан. Боловсролын 9 байгууллагад нийт 1537 хүнийг хамруулан “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай”, “Хүүхдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”-ийн талаар ажилтан албан хаагч, сурагчдын дунд сургалт зохион байгуулсан. Согтууруулах ундааны чанар аюулгүй байдал, 18 насанд хүрээгүй хүн ажиллуулж байгаа эсэхэд шалгалт хийж ЕБС-ийн орчмын болон зочид буудал, бар, хүнсний дэлгүүр нийт 41 ААН-д шалгалт хийж архи согтууруулах</p> |

| | | | |
|---|---|--|--|
| | | | <p>ундааны дагалдах бичиг баримтын бүрдэл дутуу, хадгалалтын хугацаа дууссан согтууруулах ундаа худалдан борлуулсан, хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зураагүй, 18 насанд хүрээгүй хүүхэд ажиллуулж байсан зэрэг нийт 21 зөрчил илрүүлэн хадгалалтын хугацаа дууссан 3 нэр төрлийн 168 ширхэг, 52,4 л 273450 төгрөгийн шар айргийг 7 аж ахуйн нэгжээс татан авалт хийлгэж, насанд хүрээгүй хүн ажиллуулж байгааг газар дээр нь зөрчлийг арилгуулах арга хэмжээ авав.</p> <p>“Хуулиа мөрдье-21” хэлэлцүүлгийг 2018 оны 02 сарын 08-ны өдөр зохион байгуулж МХГ, ЦГ, ГБХЗХГ, БСУГ, төрийн бус байгууллагууд, оюутан сурагч, иргэдийн төлөөлөл оролцож “ААНБ, иргэд, хуулиа мөрдөж чадвал 21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдахгүй, үйлчлэхгүй байх нөхцөл бүрдэнэ” гэсэн уриалгыг гаргасан.</p> <p>“Хуулиа мөрдье-21” сарын аяны хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар ЗДТГ-ын Мэдээлэл технологийн албаны Darkhan gov.mn сайтаар шууд ярилцлагад оролцож лайв хийж иргэдийн сонирхсон асуултад хариулсан.</p> |
| 7 | <p>4 сумын ЗДТГазар болон ОБГазар хамтран нөөцийн өвс борлуулалтад анхаарах 4 сум нөөцийн өвсөө борлуулахдаа өөр өөр үнээр зарж байгаа учраас иргэд аль хямд зарж байгаа газраас нөөцийн өвс авах сонирхол үүснэ. Зөвхөн өөрийн сумын иргэдэд нөөцийн өвсөө борлуулах тал дээр анхаарах, мөн нөөцийн өвсийг их хэмжээгээр авч байгаа аж ахуй нэгж байгууллагуудад хяналт тавих хямд үнээр аваад цааш нь малчдад үнийг нь өсгөж зарах асуудал гарахаас урьдчилан сэргийлэх</p> | <p>Сумдын ЗДТГ, Онцгой байдлын газар</p> | <p>Орхон, Хонгор сумын нөөцөд хадгалагдаж байгаа 4000 боодол өвс нөөцөөс гараагүй байна. ОБГ-ын өвсний улсын нөөцөөс 3040 боодол өвс Шадар сайдын шийдвэрээр Орхон аймагт хуваарилагдан ачигдсан байна.</p> <p>Орхон Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар тогтоолоор 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн аюулгүйн нөөцийн өвсийг худалдан борлуулах нэг боодол өвсний үнийг 4500 төгрөгөөр худалдан борлуулахаар тогтоолоо.</p> <p>Сумын аюулгүйн нөөцийн худалдан борлуулах өвсний үнийн талаарх мэдээллийг 181 малчин, мал бүхий өрхөд хүргүүлээ.</p> <p>Тус сумын 500 малчин, мал бүхий өрхөд 40330 мянган толгой мал өвөлжиж байна. Өнөөдрийн байдлаар малын зүй бус хорогдол</p> |

| | | | |
|----|--|---|--|
| | | | <p>гараагүй байна. Тус сумын малчин, мал бүхий 471 өрх 8970 тн өвс бэлтгэснээс 40 хувь буюу 3588 тн өвсийг зарцуулсан дүнтэй байна.</p> |
| 8. | <p>Малын өвчлөл, вакцинжуулалт, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, албаны холбогдох мэргэжилтнүүдийг малчин айл өрхөөр явуулж санал сонсох, эргэж хяналт тавих, малын голомтоос мал шилжиж ирэхээс урьдчилан сэргийлэх</p> | <p>Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар</p> | <p>МХГ-ын төлөвлөгөөт шалгалтаар "Мөнжөөлэй" ХХК-ийн мал эмнэлгийн үйл ажиллагаанд 1.15.1 кодтой Мал эмнэлгийн үйл ажиллагааг шалгав. Шалгалтаар тус мал эмнэлэг нь Дархан сумын 2, 3 дугаар багийн 2 ААНБ, 222 малчин, мал бүхий өрхийн 4367 толгой бод мал, 7683 толгой бог мал, 250 амьтанд эмчилгээ үйлчилгээ үзүүлж, 11 төрлийн вакцинд хамруулж өрхийн эрүүл мэндийн дэвтэрт бүртгэлийг бүрэн хийсэн байна. Тарилга, туулгалт, угаалгын актыг хөтөлж архивлан вакцины акт, түүний зарцуулалтыг цаг тухай бүр ХХААГ-ын мал эмнэлгийн албаар баталгаажуулсан байна. Хяналт шалгалт үргэлжлэн хийгдэж байна. Малын шилжилт хөдөлгөөн: Хонгор суманд Сэлэнгэ Төв, Увс аймгийн 1001 толгой мал өвөлжиж байна. Тус сумаас Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 12 малчин өрхийн 2456 толгой бод, бог мал оторлож байна. Орхон сумын 1 иргэн Улаанбаатар хотын Сонгинхайран дүүргийн 21-р хорооноос 60 хонь,70 ямаа нийт 130 толгой мал тээвэрлэж ирсэн мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээтэй, шүлхий болон цэцэг өвчний вакцинжуулалтад хамрагдсан байна. Шарын гол сум Сэлэнгэ аймгийн Мандал суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан сумын ЗДТГ, Цагдаагийн тасаг, ОБГУА-55р анги хамтарч Баянгол, Мандал сумдаас Шарын гол сум руу ирэх чиглэлийн төв зам дагуу, хүн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих 24 цагийн байнгын постыг 2017.11.20-12.08-ныг хүртэл Мандал сумтай хиллэдэг Гахайт, Ар сүүж зэрэг газрын чиглэлд хөдөлгөөнт эргүүлийг 2018.01.28-нийг хүртэл ажиллуулсан. Энэ хугацаанд малын шилжилт хөдөлгөөн</p> |

| | | | |
|-----|--|--|---|
| | | | <p>хийгдээгүй байна. Шарын гол сумаас 2017 оны 11 дүгээр сараас өнөөдрийг хүртэл нийт 728 толгой мал шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Малчин өрхөд малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай бүтээгдэхүүн оруулахыг хориглосон тухай Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны А/349 дугаар захирамжийг сурталчилж 299 өрхөд зөвлөмж, сэрэмжлүүлгийг тараасан</p> <p>Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан “Хяналтын цэг ажиллуулах тухай” удирдамжийн дагуу тус сумын ЗДТГ-ын 2 мэргэжилтэн “Буурал хангай 40” постонд батлагдсан хуваарьт өдрүүдэд 12 удаа ажиллалаа. Малыг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмжийг 120 малчин, мал бүхий өрхөд хүргүүлээ.</p> |
| 9. | <p>Малын өвчлөлтэй холбоотой Засгийн газрын тогтоол ирүүлснийг ХОХБТХэлтэст шилжүүлсэн байгаа уг тогтоолыг сумдад хүргүүлэх тогтоолын хэрэгжилтийг хангах ажиллахад анхаарах</p> | <p>Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс</p> | <p>ЗД-ын орлогчийн 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан хуваарийн дагуу Буурал хангай авто тээврийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгт Малыг гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн МХГ-ын 4 улсын байцаагч хяналт тавьж ажиллаа. Урьдчилан сэргийлэх шалгалтаар нийт 448 тээврийн хэрэгсэл, 744 иргэнийг хамруулан үзлэг шалгалт хийлээ. Шалгалтын явцад барилгын болон ахуйн хог хаягдал тээвэрлэж явсан тохиолдол гараагүй.</p> <p>Дархан сумын нутаг дэвсгэр дэх Бараат хогийн цэгийн орчим ил задгай хог хаяж шатаасан гомдол мэдээллийг хүлээн авч зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж байна.</p> |
| 10. | <p>Цагаан сарын үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцдог Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Хэний аймаг гэх мэт аймгуудад сайтар мэдээлэл өгөх</p> | <p>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс</p> | <p>Цагаан сар-2018 үзэсгэлэн, худалдааг “Эх орны бүтээгдэхүүнээ хэрэглэцгээе” уриан дор 02 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд буюу 5 хоног Залуучууд театрт зохион байгуулна. Өнөөдрийн байдлаар 100 гаруй өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид бүртгүүлээд байна.</p> |
| 11. | <p>Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас тендерт оролцож байгаа байгууллагуудаас зураг төсвийг /Багийн төвийн байр,</p> | <p>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн</p> | <p>Тендерт оролцож байгаа байгууллагуудаас 12, 16-р багийн Багийн хөгжлийн төвийн барилгын зураг төсвийг гүйцэтгэгчээр “Баянтөхөм шандат” ХХК гүйцэтгэж</p> |

| | | | |
|-----|--|--|---|
| | <p>цэцэрлэгийн зураг төсөв гэх мэт/ яаралтай шахаж авч дуусгах, улсын магадлалд оруулах</p> | <p>хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалты газар</p> | <p>байгаа ба Ажлын зураг дууссан АЗДТГ-тай гэрээ хийгдээгүйн улмаас экспертээр орж амжаагүй байгаа ажлын явц 90%-тай явагдаж байна.</p> <p>15-р багийн “Багийн хөгжлийн төв”- ийн барилгын зураг төсвийг гүйцэтгэгчээр “Жаргалант хийц” ХХК гүйцэтгэж байгаа ажлын явц 90%-тай явагдаж байгаа ажлын зураг дууссан 02.16-нд магадлалаар оруулж 2018.02.23-нд зураг төсвийг бэлэн болгоно.</p> <p>Гэрэлтэй гудамж, Гадна фасадны гэрэлтүүлэг, Залуучууд театрын зогсоол, Гадна тохижилтын зураг төсвийг гүйцэтгэгчээр “Зууны гүүр” ХХК. Техникийн нөхцөл 18.02.06-ны өдөр ирсэн. Зураг, төсөв 95%-тай хийгдсэн 02.09-нд магадлалаар өгнө эцсийн байдлаар 02.16-нд дуусна.</p> <p>“Миний монгол цэцэрлэгт хүрээлэн”-ийн зураг төсвийг “Минж бар” ХХК гүйцэтгэж байна. Өндөржилтийн зураг 02.08-нд бэлэн болно. 02.09-нд зураг бэлэн болж 02.16-нд магадлалаар орж бэлэн болгоно. Ажлын явц 95%-тай явагдаж байна.</p> <p>“Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2020-2035он”-төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгчээр “Арт констракшн” ажиллаж байна. БХБЯ-нд 2018.02.05-06-ны хооронд хуралдаж тодорхой шийдлүүдэд хүрсэн ба Цагаан сарын дараа 2сарын сүүлээр Дархан-Уул аймгийн ЗДТГ-т хийгдэж байгаа ажлаа танилцуулна.</p> <p>Дахин төлөвлөлтийн зураг төсвийг “Хангайн нар” ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 80%-тай явагдаж байна. Зургийн ажил 02.25нд дуусаж магадлалаар оруулна.</p> <p>3 цэцэрлэгийн зураг гүйцэтгэх шатанд явж байна.</p> |
| 12. | <p>Үйлдвэрийн районд шинээр хогийн цэг үүсэж байгаа тухай иргэний мэдээлэл ирсний дагуу постын хяналтыг тавихдаа хотоос гарч байгаа авто машинуудын ачааг шалгаж, хяналт тавих шаардлагатай байна. Цагдаагийн газар,</p> | <p>Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Захирагчийн алба, Дархан сумын</p> | <p>Хотын гадна талд буюу зориулалтын бус газар үүсэж байгаа хог хаягдалд үзлэг хийв.</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн районы цементийн үйлдвэрийн цаана хуучны хогийн цэг байсан газар иргэдийн хог хаягдлын цэг үүссэн байна. |

| | | | |
|-----|---|--|---|
| | Мэргэжлийн хяналтын газар, Захирагчийн алба, Дархан сумын ЗДТГазар, Онцгой байдлын газар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, Захирагчийн алба хогийн цэг шинээр бий болохоос урьдчилан сэргийлэх | ЗДТГазар, Онцгой байдлын газар | <ul style="list-style-type: none"> • Дархан сумын 5, 6, 7 дугаар багуудын хотын гадна тойрог буюу гэр хорооллын дунд мөн хогийн цэг үүссэн. • Ирэх 7 хоногт Дархан сумын 1 2, 3-р багийн хороолол дунд үзлэг хийх төлөвлөгөөтэйгээр НААҮГ ажиллаж байна. |
| 13. | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс өвлийн хүлэмжийн асуудал анхаарлаа хандуулах хууль, дүрэм, гэрээг судалж хэрхэн шийдвэрлэх талаар анхаар ч ажиллах, холбогдох удирдлагуудыг дуудаж уулзах | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс | НААҮГ-т баригдаж байгаа “Өвлийн хүлэмж”-ний ажлыг Улаанбаатар хотын “СДММС ХХК” гүйцэтгэж байна. “СДММС ХХК” зарим шаардлага хангахгүй материал нийлүүлсэн. Мөн хугацаандаа ажлаа гүйцэтгэхгүй 2 удаа гэрээг сунган ажилласан байна. Энэ чиглэлээр ХОХБТХ, Барилга захиалагчийн алба, НААҮГ, Захирагчийн алба хамтарсан хурлыг хийж ажлыг эрчимжүүлэн дуусгах шийдвэрийг гаргалаа. |
| 14. | Орон нутгийн өмчийн газар, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс тендерийн үйл ажиллагаанд анхаарах | Орон нутгийн өмчийн газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс | Орон нутгийн өмчийн газар нь 2018 онд хэрэгжүүлэх 81 төсөл арга хэмжээнээс 10 төсөл арга хэмжээнд худалдан авалтыг зохион байгуулж, зарласан. Явц: 2 тендер албажих шатандаа, 4 тендер үнэлгээний шатандаа, 1 тендер сангийн яаманд гомдол гаргаж дахин хянагдах шатандаа, 3 тендер зарлагдсан нээгдээгүй байна. |
| 15. | Татварын орлогын бүрдүүлэлтэд анхаарах | Татварын хэлтэс | Аймгийн ИТХ-р батлагдсан 2018 оны орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний сар, улирал, жилийн хуваарийн дагуу 1 дүгээр сард 1,682.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,510.5 сая төгрөг төвлөрүүлж 89.7 хувьтай, Улсын төвлөрсөн төсвийн орлогоор сардаа 188.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 100 хувийн гүйцэтгэлтэй буюу 1 сарын төлөвлөгөөг биелүүлж ажиллалаа.Төсвийн орлогыг бүрдүүлэхэд төсвийн байгууллагын дулаан,цахилгааны төлбөрийг ДДЦС,Шарын гол ХК-ны татварт 1 дүгээр сард нийт 214.9 сая төгрөг хаалтаар татварын орлогод орууллаа. |
| 18. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөмж өгөх шаардлагатай байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналтын хүрээнд 41 заалт бүхий “Зөвлөмж”-ийг боловсруулан, аймгийн Засаг даргаар батлуулж аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын “Мэдээллийн |

| | | |
|-----|--|--|
| | <p>Зөвхөн үнэлгээ хийж байна. Хөтөлбөр ямар учир шалтгаанаар хэрэгжилт 30%, 70% гарсан, ямар гарц байна. Төлөвлөлт болон цаашид хэрхэн засах талаар зөвлөн туслах үйлчилгээ өгөх шаардлагатай байна.</p> | <p>цаг"-аар /2018.02.09/ нийт 39 албан хаагчдад хүргэсэн. Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсийн дарга нарт бичгээр хүргүүлж, "Зөвлөмж"-ийг харьяа агентлагуудын удирдлага, албан хаагчдад өгөх чиглэлийг өгч ажилласан.</p> <p>Нутгийн захиргааны байгууллагуудад 2018 онд явцын хяналт-шинжилгээ буюу зөвлөн туслах үйл ажиллагааны хуваарийг 2018.01.30-нд аймгийн Засаг даргаар батлуулж, able cloud, хэлтсийн фэйж хуудсанд байршуулсан.</p> |
| 19. | <p>Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй боловч хийсэн ажил нь байна. Зарим газрууд үүрэг даалгаврын хэрэгжилт өгөхгүй байна. 1 дүгээр сарын шуурхай хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилт танилцуулагдаж байсан. Үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2 дугаар сарын эхэнд дүнг танилцуулж арга хэмжээ авах</p> | <p>Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс</p> <p>1 дүгээр сард нийт 4 удаагийн Шуурхай хурлыг зохион байгуулж тухай бүр тэмдэглэлийг гаргаж баталгаажуулах хэлтсүүдэд хүргүүлж 3 удаагийн үүрэг даалгаврын хэрэгжилтийг авч нэгтгэн шуурхай хуралд танилцуулж ажиллаа. 4 дэх хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийг ирүүлэх хугацааг дууссаны дараа ХШҮДАХ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна .</p> |

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ